

**2014-2015 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬД
ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДЭД ЗОРИУЛСАН
ЗӨВЛӨМЖ №1**

Нэг. БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ СУРГАЛТЫН ТӨВШИНГӨӨ СОНГОХ:

- 1.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалт
- 1.2. Бакалаврын зэрэг олгох сургалт
- 1.3. Удирдлагын сургуульд мэргэжил олгох, боловсролын зэрэг ахиулах сургалт
- 1.4. Магистр, докторын зэрэг олгох сургалт

Хоёр. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТАД БҮРТГҮҮЛЭХ ХУГАЦАА:

1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүсэгчдийг 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд 18.00 цаг хүртэл цахим хэлбэрээр бүртгэнэ.
2. Бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгчдийг 2014 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийн 18.00 цаг хүртэл цахим хэлбэрээр бүртгэнэ.
3. Удирдлагын сургуульд элсэхийг хүсэгчдийг захиалагч агентлаг, байгууллагуудын холбогдох нэгжүүдтэй хамтран 2 үе шаттайгаар 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 20-ны өдрүүдэд бүртгэнэ.
4. Магистр, докторын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгчдийг 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 2014 оны 09 дүгээр сарын 10-ны өдрүүдэд цахим хэлбэрээр бүртгэнэ.

Гурав. ЦАХИМ БҮРТГЭЛИЙН САНД БҮРТГҮҮЛЭХ ДАРААЛАЛ:

Алхам 1:

Элсэлтийн шалгалт зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн баримт бичгүүдтэй танилцах.

1. "ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам"- /ХСИС-ийн захирлын 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Б/286 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт/
2. "ХСИС-ийн мэргэжлийн боловсрол, сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам /ХСИС-ийн захирлын 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Б/286 дугаар тушаалын 2 дугаар хавсралт/
3. "ХСИС-ийн бакалаврын сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам"-/ХСИС-ийн захирлын 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Б/286 дугаар тушаалын 3 дугаар хавсралт/
4. "ХСИС-ийн Удирдлагын сургуульд элсүүлэн суралцуулах журам"-/ХСИС-ийн 2013 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/170 дугаар тушаал/
5. ХСИС-ийн "Магистр, докторын сургалтын журам"- /ХСИС-ийн захирлын 2013 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/33 дугаар тушаал/

Алхам 2:

ХСИС-д элсэхийг хүсэгчид тавих нийтлэг шаардлагыг хангаж буй эсэхээ тодорхойлох:

1. Нүүрний хэлбэр төрх зөв байх;
2. Ил харагдах 20X05 мм-ээс том сорви, шивээсгүй байх;
3. Бие эрхтний гэмтэл согоггүй, эрүүл байх;
4. Биеийн өндөр: Эрэгтэй 165 см ба түүнээс дээш, эмэгтэй 160 см ба түүнээс дээш байх;
5. Боловсролын зэрэг олгох тухайн сургалтын төвшинд тавигдах насны хязгаарт нийцсэн байх;
 - 5.1. Мэргэжлийн боловсрол, бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүсэгч эрэгтэй 17-оос 25 хүртэл, эмэгтэй 17-20 хүртэл настай байх;
 - 5.2. Бакалаврын төвшний эчнээ сургалтад элсэхийг хүсэгч алба хаагч нь тухайн агентлаг, байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актуудаар тогтоосон насны хязгаарт нийцсэн байх;

Алхам 3:

ХСИС-д элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлагыг хангаж буй эсэхээ тодорхойлох:

1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүсэгч:
 - 1.1. Ерөнхий шалгалтын батламж хүчинтэй байх;
 - 1.2. Суурь ба хавсралт шалгалтын оноо чанарын онооны босгыг хангасан байх;
 - 1.3. Бакалаврын боловсролын дипломын голч дүн 2.4 буюу түүнээс дээш байх;
2. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүсэгч:
 - 2.1. Мэргэжлийн үнэмлэхний голч дүн 2.4 буюу түүнээс дээш байх;
 - 2.2. Ерөнхий шалгалтын батламж хүчинтэй байх;
 - 2.3. Суурь шалгалтын босго оноо 560 ба хавсралт шалгалтын босго оноо 400 буюу түүнээс дээш байх;
3. Бакалаврын зэрэг олгох 5.5 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч:
 - 3.1. Ерөнхий шалгалтын батламж хүчинтэй байх;
 - 3.2. Суурь шалгалтын босго оноо 560 ба хавсралт шалгалтын босго оноо 400 буюу түүнээс дээш байх;
 - 3.3. Холбогдох журмаар зөвшөөрөгдсөн насны хязгаарт багтсан байх;
 - 3.4. Суралцахыг дэмжсэн зөвшөөрөлтэй байх;

4. Бакалаврын зэрэг олгох 3 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч:

- 4.1. ХСИС-ийн элсэлтийн комиссоос авах суурь шалгалтын босго оноо 500, хавсралт шалгалтын босго оноо 400 буюу түүнээс дээш байх;
- 4.2. Суралцахыг дэмжсэн зөвшөөрөлтэй байх;

Алхам 4: ХСИС-ийн элсэлтийн цахим бүртгэлийн санд бүртгүүлэх:

НЭГ. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН БҮРТГЭЛ

1.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүссэн бүрэн болон тусгай дунд боловсролтой иргэн:

- Цахим бүртгэлийн хуудасны "Боловсролын төвшин" цонхноос "МБ-БДБ" /мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүссэн бүрэн дунд болон тусгай дунд боловсролтой иргэн/ цэсийг сонгоно.

1.2. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүссэн дээд боловсролтой иргэн:

- Цахим бүртгэлийн хуудасны "МБ-ДБ" /мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүссэн дээд боловсролтой иргэн/ цэсийг сонгоно.

1.3. Дээрх элсэхийг хүсэгчид "Мэргэжлийн чиглэл" цонхноос суралцахыг хүссэн сургууль, мэргэжлээ сонгоно.

1. "Цагдаа: АС01" Ахлагчийн сургуульд цагдаагийн мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөөд Цагдаагийн сургуульд "Цагдаа-Хууль сахиулах ажил", "Шүүх шинжилгээ-Хууль сахиулах ажил" мэргэжлээр бакалаврын төвшинд тус тус шатлан суралцана.
2. "Хилийн харуулын дарга: АС02" Ахлагчийн сургуульд "Хилийн харуулын дарга" мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөөд Хилийн сургуульд "Хилийн алба" мэргэжлээр бакалаврын төвшинд шатлан суралцана.
3. "Хилийн шалган нэвтрүүлэх албаны шалгагч: АС03" Ахлагчийн сургуульд "Хилийн шалган нэвтрүүлэх албаны шалгагч" мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөөд Хилийн сургуульд "Шалган нэвтрүүлэх алба- хууль сахиулах ажил" мэргэжлээр бакалаврын төвшинд шатлан суралцана.
4. "Харуул хамгаалалтын ажилтан: АС04" Ахлагчийн сургуульд "Харуул хамгаалалтын ажилтан" мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуульд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-Хууль сахиулах ажил" мэргэжлээр бакалаврын төвшинд шатлан суралцана.
5. "Аврагч: АС05" Ахлагчийн сургуульд "Аврагч" мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөөд Онцгой байдлын сургуульд "Онцгой байдал-Гамшгаас хамгаалах алба" мэргэжлээр бакалаврын сургалтад шатлан суралцана.

ХОЁР. БАКАЛАВРЫН ЗЭРЭГ ОЛГОХ ӨДРИЙН СУРГАЛТЫН БҮРТГЭЛ:

2.1. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүссэн ХСИС-д мэргэжлийн боловсрол эзэмшсэн сонсогч:

- Цахим бүртгэлийн хуудасны "Боловсролын төвшин" цонхноос "БЗ-МБС" /бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүссэн Ахлагчийн сургуульд мэргэжлийн боловсрол эзэмшсэн сонсогч / цэсийг сонгоно.

2.2. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүссэн мэргэжлийн боловсрол эзэмшсэн алба хаагч:

- Цахим бүртгэлийн хуудасны "Боловсролын төвшин" цонхноос "БЗ-МБАХ" /бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүссэн Ахлагчийн сургуульд мэргэжлийн боловсрол эзэмшсэн алба хаагч/ цэсийг сонгоно.

2.3. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүссэн дээд боловсрол эзэмшсэн алба хаагч:

- Цахим бүртгэлийн хуудасны Боловсролын төвшин" цонхноос "БЗ-ДБАХ" /бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүссэн дээд боловсрол эзэмшсэн алба хаагч/ цэсийг сонгоно.

2.4. Дээрх элсэхийг хүсэгчид "Мэргэжлийн чиглэл" цонхноос суралцахыг хүссэн сургууль, мэргэжлээ сонгоно.

1. "Цагдаа-Хууль сахиулах ажил" - ЦС01
2. "Шүүх шинжилгээ-Хууль сахиулах ажил" -ЦС02
3. "Хилийн алба" -ХС01.
4. "Шалган нэвтрүүлэх алба-Хууль сахиулах ажил" -ХС02
5. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл -Хууль сахиулах ажил"-ШШГС01
6. "Онцгой байдал-Гамшгаас хамгаалах алба"-ОБС01

ГУРАВ. БАКАЛАВРЫН ЗЭРЭГ ОЛГОХ ЭЧНЭЭ СУРГАЛТЫН БҮРТГЭЛ:

3.1. Бакалаврын зэрэг олгох 5.5 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүссэн бүрэн дунд боловсрол эзэмшсэн алба хаагч:

- Цахим бүртгэлийн хуудасны “Боловсролын төвшин” цонхноос “БЗ-5.5”/бакалаврын зэрэг олгох 5.5 жилийн эцнээ сургалтад элсэхийг хүссэн бүрэн дунд боловсрол эзэмшсэн алба хаагч/ цэсийг сонгоно.
- 3.2. Бакалаврын зэрэг олгох 3 жилийн эцнээ сургалтад элсэхийг хүссэн дээд боловсрол эзэмшсэн алба хаагч:**
- Цахим бүртгэлийн хуудасны “Боловсролын төвшин” цонхноос “БЗ-3”/бакалаврын зэрэг олгох 3 жилийн эцнээ сургалтад элсэхийг хүссэн дээд боловсрол эзэмшсэн алба хаагч/ цэсийг сонгоно.
- 3.3. Дээрх элсэхийг хүсэгчид “Мэргэжлийн чиглэл” цонхноос суралцахыг хүссэн сургууль, мэргэжлээ сонгоно.**
1. “Цагдаа-Хууль сахиулах ажил”- ЦСО1
 2. “Хилийн алба” –ХСО1.
 3. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл -Хууль сахиулах ажил”-ШШГС01

Алхам 5:

МЭДЭЭЛЛЭЭ ОРУУЛАХ:

1. Элсэхийг хүсэгч сонгосон цэсэндээ цахим бүртгэлийн програмаас өгөгдөх зааварчилгааны дагуу мэдээллээ оруулан бүртгүүлнэ.
2. Бүртгүүлсэн элсэхийг хүсэгчийн цахим хаягаар нь нууц кодыг илгээнэ.

Алхам 6:

ЦАХИМ БҮРТГЭЛИЙН САНД ХАНДАХ:

1. Бүртгүүлсэн элсэхийг хүсэгч хувийн нууц кодоороо элсэлтийн цахим бүртгэлийн санд нэвтрэн, элсэлтийн комиссоос илгээсэн өөрийн бүртгэлийн хуудсан дахь мэдээллүүдтэй танилцах эрхтэй.
2. Элсэлтийн комисс элсэхийг хүсэгчдийн суурь болон хавсралт хичээлийн ерөнхий шалгалтын дүн БҮТ-өөс зарлагдсаны дараа оноог татан авч, чанарын онооны томъёогоор тооцон, ХСИС-ийн элсэлтийн шалгалтын босго онооны болзол хангасан элсэхийг хүсэгчдийн жагсаалтыг гарган цахим хуудсанд 2014 оны 07 дугаар сарын 01-ний дотор байршуулсан байна.
3. Элсэлтийн комисс жагсаалтад багтсан элсэхийг хүсэгчдийн шалгалтын хуудсанд ерөнхий шалгалтын дүн, чанарын оноог оруулсны дараа элсэхийг хүсэгч шалгалтын хуудсаа хэвлэн авснаар дараагийн шатны шалгалтуудад орох эрх үүснэ.

Дөрөв. ХСИС-ИЙН НЭМЭЛТ ШАЛГАЛТ

1. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТАД ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИД:

1.1. Элсэхийг хүсэгчид тавих нийтлэг шаардлага хангасан эсэхийг тодорхойлох үзлэгт орох

Шалгалтын хуудас бүхий элсэхийг хүсэгч “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”-ын 4.2 дахь хэсэгт заасан “Элсэхийг хүсэгчид тавих нийтлэг шаардлага”-ыг хангасан эсэхийг тодорхойлох үзлэгт 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд 08.30-17.00 цагт орж, зохих тэмдэглэлийг хийлгэнэ.

Бэлтгэж ирэх зүйлс:

1. Шалгалтын хуудас
2. Иргэний үнэмлэх
3. Цээж зураг-4х3-1%

Тэнцсэн элсэхийг хүсэгчид дараагийн шатны үзлэгийн “Эрүүл мэндийн үзлэгийн хуудас” -ыг олгоно.

1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ

Батлан хамгаалах Хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд 08.00-16.00 цагт хамрагдана.

Бэлтгэж ирэх зүйлс:

1. Эрүүл мэндийн дэвтэр
2. Үзлэгийн хураамж 15000 төг
3. Иргэний үнэмлэх
4. Эрүүл мэндийн үзлэгийн хуудас

Мөн 2014 оны 06 дугаар сарын 23-аас 2014 оны 07 дугаар сарын 03-ны хугацаанд хийлгүүлсэн дараах шинжилгээнүүдийн хариуг авчирна. Үүнд:

1. Биохимийн шинжилгээ /элэгний үйл ажиллагаа/
2. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
3. Шээсний ерөнхий шинжилгээ
4. Эхо- Хэвлий /зурагтай/
5. Флюорографийн зураг
6. Зүрхний цахилгаан бичлэг

1.3. БИЕ БЯЛДРЫН ШАЛГАЛТ”-Д ОРОХ

Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн элсэхийг хүсэгчид “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”-ын 6.1.3.1 дэх заалтад заасан 5 чанарын шалгуур үзүүлэлтээр бие бялдрын шалгалтад орно. Бие бялдрын шалгалтыг 2014 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрүүдэд 08.30-17.00 цагт ХСИС-ийн байрлалд авна.

Бэлтгэж ирэх зүйлс:

1. Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн дүгнэлт бүхий хуудас
2. Шалгалтын хуудас
3. Иргэний үнэмлэх

4. Иж бүрэн бэлтгэлийн хувцас

1.4. "СЭТГЭЛ ЗҮЙН СОРИЛ, ЯРИЛЦЛАГА"-Д ОРОХ

Бие бялдрын шалгалтын босго онооны бэлзэл хангасан элсэхийг хүсэгчид "ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам"-ын 6.1.3.2 дахь заалтад заасан "Сэтгэл зүйн сорил,ярилцлага"-д орно. Сорилын шалгалт 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдөр 08.30 цагт эхэлнэ.

Бэлтгэж ирэх зүйлс:

1. Иргэний үнэмлэх
2. Шалгалтын хуудас
3. Үзэг, харандаа

2. БАКАЛАВРЫН ӨДРИЙН СУРГАЛТАД ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИД:

2.1. Бакалаврын зэрэг олгох өдрийн ангид суралцахыг хүссэн дээд боловсролтой алба хаагч болон эчнээ хэлбэрийн 3 жилийн сургалтад элсэхийг хүсэгч алба хаагчид ХСИС-ийн "Бакалаврын зэрэг олгох сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам"-ын 2.1.1 дэх заалтад заасан суурь ба хавсралт шалгалтуудыг 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 26-ны өдрүүдэд 09.00 цагт өгнө.

3. УДИРДЛАГЫН СУРГУУЛЬД ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИД:

3.1. ХСИС-ийн "Удирдлагын сургуульд элсүүлэн суралцуулах журам"-аар заасан нэмэлт шалгалтуудыг уг журмаар тогтоосон хугацаанд өгнө.

4. МАГИСТР, ДОКТОРЫН ЗЭРЭГ ОЛГОХ СУРГАЛТАД ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИД:

4.1. ХСИС-ийн "Магистр, докторын сургалтын журам"-ын 3.2.1 дэх заалтад заасан шалгалтуудыг уг журмаар тогтоосон хугацаанд өгнө.

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТИЙН КОМИСС